



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 7048-4030,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 02. 04 № 02  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЛТАЙ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Э.МАРАЛМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 1907 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн ба өмнөх оны авлага барагдуулж 141,210.4 мянган төгрөгийг санхүүжилтийг олгосон байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 24,610.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй ирсэн 67,229.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.

**Аудитын гол асуудал**

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 830,185.7 мянган төгрөгийг нэхэмжилснээс 796,434.5 мянган төгрөг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигдэж, 6,179.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж, 27,571.8 мянган төгрөг авлагаар тайлагнагдсан байна.

822505000008

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 14 дүгээр тогтоолоор төсөвт тодотгол хийж түлш халаалтын зардлыг 35,391.2 мянган төгрөгөөр бууруулж баталснаар, 13,033.0 мянган төгрөгийн өртэй гарсан байна.

Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны А/413, А/151 дүгээр тушаалын дагуу 1 дүгээр ангийн сурагчдын нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулахад Эрүүл мэндийн даатгалын сангаас 8,162.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ хэрэгжүүлэхээр сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан гүйцэтгэлээр 84.3 хувиар дүгнүүлжээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлт 84.8 хувьтай байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Р.ГҮНЖИДМАА

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан СТ-1 (төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>5,083,133.94</b>	<b>11,118,693.36</b>
Банкинд байгаа бэлэн мөнгө/ төгрөгөөр/	5,083,133.94	11,118,693.36
Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгө	5,083,133.94	11,118,693.36
<b>АВЛАГА</b>	<b>149,940,185.95</b>	<b>34,652,597.67</b>
Төлбөртэй үйлчилгээний авлага	141,210,387.02	27,571,792.67
<b>Бусад авлага</b>	<b>8,729,798.93</b>	<b>7,080,805.00</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,648,993.93	-
Хувь хүмүүсээс авах авлага	7,080,805.00	7,080,805.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>116,332,318.37</b>	<b>121,332,867.12</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>43,594,866.31</b>	<b>38,807,725.22</b>
Тусгай зориулалттай материал	672,000.00	672,000.00
Эм боох материал	42,922,866.31	38,135,725.22
<b>Хангамжийн материал</b>	<b>72,737,452.06</b>	<b>82,525,141.90</b>
Бичиг хэргийн материал	660,500.00	217,000.00
Аж ахуйн материал	1,803,500.00	3,496,374.33
Сэлбэг хэрэгсэл	370,000.00	370,000.00
Түлш, шатах тослох материал	19,470,000.00	20,058,430.00
Хүнсний материал	1,113,285.00	3,076,479.00
Бусад хангамжийн материал	49,320,167.06	55,306,858.57
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>271,355,638.26</b>	<b>167,104,158.15</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>770,951,976.37</b>	<b>787,671,360.75</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>744,279,976.37</b>	<b>760,999,360.75</b>
Барилга, байгууламж, орон сууц	570,699,612.08	587,887,612.08
Хуримтлагдсан элэгдэл	(73,654,630.61)	(86,303,142.65)
Авто-тээврийн хэрэгсэл	135,359,613.00	157,197,834.77
Хуримтлагдсан элэгдэл	(64,690,168.50)	(81,125,952.42)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	298,735,909.87	351,489,045.03
Хуримтлагдсан элэгдэл	(182,931,693.09)	(215,604,317.73)
Тавилга, аж ахуйн эд хогшил	104,743,684.00	104,803,358.23
Хуримтлагдсан элэгдэл	(43,982,350.38)	(57,345,076.56)
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>26,672,000.00</b>	<b>26,672,000.00</b>
Бусад	26,672,000.00	26,672,000.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>770,951,976.37</b>	<b>787,671,360.75</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,042,307,614.63</b>	<b>954,775,518.90</b>
Бараа үйлчилгээний зардлын өглөг		13,033,000.00
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>-</b>	<b>13,033,000.00</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>-</b>	<b>13,033,000.00</b>
Засгийн газрын хувь оролцоо	348,310,192.08	348,310,192.08
Дахин үнэлгээний нэмэгдэл	160,931,595.46	160,931,595.46
Хуримтлагдсан үр дүн	533,065,827.09	432,500,731.36

ГАА-2026/160/НА-СТА-ТШЗ

<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,042,307,614.63</b>	<b>941,742,518.90</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,042,307,614.63</b>	<b>954,775,518.90</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан СТ-2** (төгрөгөөр )

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ	ТАЙЛАНТ ОНЫ
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>862,942,338.83</b>	<b>874,225,801.10</b>
Орон нутгийн төсвөөс	53,824,000.00	50,219,500.00
Нийгмийн даатгалын сангаас	809,118,338.83	824,006,301.10
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>110,949,803.54</b>	<b>86,111,161.51</b>
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	80,708,746.40	67,229,031.16
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	30,241,057.14	18,742,130.35
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		140,000.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>973,892,142.37</b>	<b>960,336,962.61</b>
<b><u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u></b>	<b>656,279,037.12</b>	<b>790,199,127.96</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>582,846,767.99</b>	<b>702,709,127.96</b>
Үндсэн цалин	355,442,149.45	412,505,939.90
Нэмэгдэл	185,476,239.04	234,063,402.54
Унаа хоолны хөнгөлөлт	6,632,000.00	8,928,000.00
Урамшуулал	35,296,379.50	47,211,785.52
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>73,432,269.13</b>	<b>87,490,000.00</b>
Тэтгэврийн даатгал	50,013,136.27	58,834,800.00
Тэтгэмжийн даатгал	5,854,781.00	7,163,800.00
ҮОМШӨ-ний даатгал	2,927,392.00	3,581,900.00
Ажилгүйдлийн даатгал	2,927,396.00	3,581,900.00
Эрүүл мэндийн даатгал	11,709,563.86	14,327,600.00
<b><u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u></b>	<b>303,205,706.28</b>	<b>264,341,588.89</b>
<b>Тогтмол зардал</b>	<b>31,154,165.54</b>	<b>38,359,658.51</b>
Гэрэл цахилгааны зардал	2,908,865.54	4,429,958.51
Түлш, халаалтын зардал	27,258,200.00	32,670,000.00
Цэвэр, бохир усны зардал	987,100.00	1,259,700.00
<b>Нормативт зардал</b>	<b>114,901,615.28</b>	<b>67,349,051.06</b>
Хоол	8,254,605.00	58,145,545.06
Эм	103,797,010.28	6,413,506.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	2,850,000.00	2,790,000.00
<b>Хангамж бараа үйлчилгээний зардал</b>	<b>65,460,253.69</b>	<b>57,162,278.54</b>
Бичиг хэргийн материал	2,220,800.00	2,300,000.00
Тээвэр, шатахууны зардал	35,049,730.00	31,438,400.00
Шуудан холбооны зардал	2,735,500.00	3,233,877.00
Хог хаягдал зайлуулах зардал	1,421,750.00	648,850.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл	6,388,981.00	5,677,885.79

Бараа материал акталсаны зардал	17,643,492.69	13,863,265.75
<b>Эд хогшил урсгал засварын зардал</b>	<b>8,298,300.00</b>	<b>8,384,000.00</b>
Урсгал засвар	8,298,300.00	8,384,000.00
<b>Томилолт зочны зардал</b>	<b>3,300,000.00</b>	<b>3,076,000.00</b>
Дотоод томилолтын зардал	3,300,000.00	3,076,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,130,126.00</b>	<b>13,411,704.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,130,126.00	12,603,954.00
Маягт хэвлүүлэх зардал		807,750.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>75,961,245.77</b>	<b>76,598,896.78</b>
Бусад зардал	4,090,150.00	1,479,250.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,871,095.77	75,119,646.78
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,834.46</b>	<b>6,361,341.49</b>
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>20,834.46</b>	<b>6,361,341.49</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	20,834.46	6,361,341.49
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>959,505,577.86</b>	<b>1,060,902,058.34</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>14,386,564.51</b>	<b>(100,565,095.73)</b>
Хөрөнгө худалдсаны гарз	672,000.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>672,000.00</b>	<b>-</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>13,714,564.51</b>	<b>(100,565,095.73)</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>727,021,145.48</b>	<b>987,864,395.45</b>
Орон нутгийн төсвөөс	53,824,000.00	50,219,500.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас	673,197,145.48	937,644,895.45
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>1,570,000.00</b>	<b>140,000.00</b>
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	1,570,000.00	140,000.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>728,591,145.48</b>	<b>988,004,395.45</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>658,607,084.80</b>	<b>788,550,134.03</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>584,493,149.82</b>	<b>701,060,134.03</b>
Үндсэн цалин	357,088,531.28	410,856,945.97
Нэмэгдлүүд	185,476,239.04	234,063,402.54
Унаа хоолны хөнгөлөлт	6,632,000.00	8,928,000.00
Урамшуулал	35,296,379.50	47,211,785.52
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>74,113,934.98</b>	<b>87,490,000.00</b>
Тэтгэврийн даатгал	50,694,802.12	58,834,800.00
Тэтгэмжийн даатгал	5,854,781.00	7,163,800.00
ҮОМШӨ-ний даатгал	2,927,392.00	3,581,900.00
Ажилгүйдлийн даатгал	2,927,396.00	3,581,900.00
Эрүүл мэндийн даатгал	11,709,563.86	14,327,600.00
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>174,993,008.10</b>	<b>179,635,360.51</b>
<b>Тогтмол зардал</b>	<b>47,805,965.54</b>	<b>26,670,158.51</b>

Гэрэл цахилгааны зардал	2,908,865.54	4,429,958.51
Түлш, халаалтын зардал	43,910,000.00	19,499,500.00
Цэвэр, бохир усны зардал	987,100.00	2,740,700.00
<b>Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал</b>	<b>53,141,661.56</b>	<b>63,011,391.00</b>
Хоол	6,450,150.00	51,844,691.00
Эм боох материал	43,841,511.56	8,376,700.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,850,000.00	2,790,000.00
<b>Хангамж бараа үйлчилгээний зардал</b>	<b>48,025,105.00</b>	<b>45,927,857.00</b>
Бичиг хэрэг	1,708,300.00	1,801,500.00
Тээвэр, шатахуун	35,049,730.00	32,164,330.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,735,500.00	3,233,877.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,421,750.00	2,148,850.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,109,825.00	6,579,300.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,378,700.00</b>	<b>26,001,000.00</b>
Багаж, техник, хэрэгсэл		365,000.00
Урсгал засвар	14,378,700.00	25,636,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,300,000.00</b>	<b>3,076,000.00</b>
Дотоод албан томилолт	3,300,000.00	3,076,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,130,126.00</b>	<b>13,466,704.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,130,126.00	12,603,954.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		862,750.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,211,450.00</b>	<b>1,482,250.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,211,450.00	1,482,250.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,834.46</b>	<b>6,361,341.49</b>
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		
Төвлөрүүлэх шилжүүлэг	20,834.46	6,361,341.49
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	833,620,927.36	974,546,836.03
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(105,029,781.88)</b>	<b>13,457,559.42</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	16,636,900.00	7,422,000.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)</b>	16,636,900.00	7,422,000.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)</b>	<b>(16,636,900.00)</b>	<b>(7,422,000.00)</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)</b>	<b>(121,666,681.88)</b>	<b>6,035,559.42</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	126,749,815.82	5,083,133.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,083,133.94	11,118,693.36

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан СТ-4

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	348,310,192.08	160,931,595.46	519,351,262.91	1,028,593,050.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			0.33	0.33
Залруулсан үлдэгдэл	348,310,192.08	160,931,595.46	519,351,262.58	1,028,593,050.12
Тайлант үеийн үр дүн			13,714,564.51	13,714,564.51
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	348,310,192.08	160,931,595.46	533,065,827.09	1,042,307,614.63
Залруулсан үлдэгдэл	348,310,192.08	160,931,595.46	533,065,827.09	1,042,307,614.63
Тайлант үеийн үр дүн			(100,565,095.73)	(100,565,095.73)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	348,310,192.08	160,931,595.46	432,500,731.36	941,742,518.90

## 2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Нийгмийн даатгалын сангийн/ СТ-4-1

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
<b>Татаас, санхүүжилтийн орлого</b>	<b>977,156,800.00</b>	<b>937,644,895.45</b>	<b>39,511,904.55</b>	<b>96.0</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас	977,156,800.00	937,644,895.45	39,511,904.55	96.0
<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>5,083,100.00</b>	<b>140,000.00</b>	<b>4,943,100.00</b>	<b>2.8</b>
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	140,000.00	(140,000.00)	-
Урьд оны үлдэгдлээс	5,083,100.00	-	5,083,100.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>982,239,900.00</b>	<b>937,784,895.45</b>	<b>44,455,004.55</b>	<b>95.5</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>802,668,100.00</b>	<b>788,550,134.03</b>	<b>14,117,965.97</b>	<b>98.2</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>715,178,100.00</b>	<b>701,060,134.03</b>	<b>14,117,965.97</b>	<b>98.0</b>
Цалин	552,292,500.00	466,996,731.49	85,295,768.51	84.6
Цалингийн тусгай нэмэгдлүүд	162,885,600.00	234,063,402.54	(71,177,802.54)	143.7
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>87,490,000.00</b>	<b>87,490,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	73,162,400.00	73,162,400.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгалын хураамж	14,327,600.00	14,327,600.00	-	100.0
<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	<b>169,609,100.00</b>	<b>135,412,202.00</b>	<b>34,196,898.00</b>	<b>79.8</b>

<b>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</b>	<b>75,730,200.00</b>	<b>60,221,391.00</b>	<b>15,508,809.00</b>	<b>79.5</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,422,200.00	51,844,691.00	13,577,509.00	79.2
Хоол, хүнс	10,308,000.00	8,376,700.00	1,931,300.00	81.3
<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	<b>93,878,900.00</b>	<b>75,190,811.00</b>	<b>18,688,089.00</b>	<b>80.1</b>
Бичиг хэргийн материал	1,813,300.00	1,801,500.00	11,800.00	99.3
Тээвэр, шатахууны зардал	48,840,600.00	32,164,330.00	16,676,270.00	65.9
Шуудан холбооны зардал	3,558,400.00	3,233,877.00	324,523.00	90.9
Дотоод томилолтын зардал	3,800,000.00	3,076,000.00	724,000.00	80.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	2,165,100.00	2,148,850.00	16,250.00	99.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,600,000.00	6,579,300.00	20,700.00	99.7
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	2,850,000.00	2,790,000.00	60,000.00	97.9
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	13,374,000.00	12,603,954.00	770,046.00	94.2
Маягт хэвлүүлэх зардал	877,500.00	862,750.00	14,750.00	98.3
Урсгал засварын зардал	8,500,000.00	8,448,000.00	52,000.00	99.4
Бусад зардал	1,500,000.00	1,482,250.00	17,750.00	98.8
<b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>	<b>9,962,700.00</b>	<b>7,787,000.00</b>	<b>2,175,700.00</b>	<b>78.2</b>
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,010,400.00	-	2,010,400.00	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	7,952,300.00	7,787,000.00	165,300.00	97.9
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>982,239,900.00</b>	<b>931,749,336.03</b>	<b>50,490,563.97</b>	<b>94.9</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,083,133.94	5,083,133.94	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,118,693.36	-	-

**2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсвийн/ СТ-4-2**

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орон нутгийн төсвөөс	50,219,500.00	43,858,158.51	6,361,341.49	87.3
Гэрэл цахилгааны зардал	10,736,300.00	4,429,958.51	6,306,341.49	41.3
Түлш, халаалтын зардал	19,500,000.00	19,499,500.00	500.00	100.0
Цэвэр, бохир усны зардал	2,795,200.00	2,740,700.00	54,500.00	98.1
Урсгал зардал	17,188,000.00	17,188,000.00	-	100.0
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>50,219,500.00</b>	<b>43,858,158.51</b>	<b>6,361,341.49</b>	<b>87.3</b>

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулагдаагүй 9,214.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн 9,214.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүлээ.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Нэг. Хандив тусламжаар ирсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 144 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ы 2 дугаар зүйлийн 2.1.3-т "хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл", Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т "Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээлийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, орон нутгийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргана". гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах, дахин үнэлгээ хийх зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт, зөвлөмж гаргуулж ажиллах.

#### Хоёр: Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой

**Илрүүлэлт:** Тайлант онд 3,035.0 мянган төгрөгийн компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмж, барааг бусад этгээдээс худалдан авахгүй байх.

#### Гурав. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэй холбоотой

**Илрүүлэлт:** Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 6,179.4 мянган төгрөг хасагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй: 13.1.1. даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх"; 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын

иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан санхүүгийн аудитын асуудал  
(мянган төгрөгөөр)**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Алтай сумын эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 6,179.4 мянган төгрөг хасагджээ.	1	6,179.4	-	-	-	-	1	6,179.4
	Тайлант онд 3,035.0 мянган төгрөгийн компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.	1	3,035.0	-	-	-	-	1	3,035.0
	Хандив тусламж болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 144 нэр төрлийн бараа материал, үндсэн хөрөнгийг орлого авахдаа байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжгүйгээр данс бүртгэлд тусгасан	1	-	-	-	-	-	-	1
	<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>9,214.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>9,214.4</b>

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийсэн хэлбэр	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	-			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			